



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 7 дугаар
сарын 3-ны өдөр

Дугаар 282


Улаанбаатар
хот

Хурдны авто зам ашигласны төлбөрийн
хэмжээг тогтоох тухай

Авто замын тухай хуулийн 30.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ НЬ:

1. "Улаанбаатар-Хөшигийн хөндийн нисэх онгоцны шинэ буудал чиглэлийн хурдны авто зам ашигласны төлбөрийн хэмжээ"-г хавсралт ёсоор тогтоосугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгаланд үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Зам, тээврийн хөгжлийн сайд

У.ХҮРЭЛСҮХ

Б.ЭНХ-АМГАЛАН

2019 оны 282 дугаар
 тогтоолын хавсралт

Засгийн газрын 2019 оны 282 дугаар тогтоолын хавсралт

**УЛААНБААТАР-ХӨШИГИЙН ХӨНДИЙН ШИНЭ НИСЭХ ОНГОЦНЫ
 БУУДАЛ ЧИГЛЭЛИЙН ХУРДНЫ АВТО ЗАМ АШИГЛАСНЫ
 ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ**

Тээврийн хэрэгслийн төрөл	Ангилал	Төлбөрийн хэмжээ (төгрөг)
Суудлын тээврийн хэрэгсэл	"B" ангиллын суудлын автомашин (жолоочоос гадна наймаас илүүгүй хүний суудалтай бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй автомашин)	2000
	"D1" ангиллын дунд оврын автобус (жолоочоос гадна арван зургаагаас илүүгүй хүний суудалтай "D" ангиллын автомашин)	10000
	"D" ангиллын том оврын автобус (жолоочоос гадна наймаас илүү хүний суудалтай, хүн тээвэрлэхэд зориулсан автомашин)	20000
	Чиглэлийн тээврийн хэрэгсэл	5000
Ачааны автомашин	Бүх жин нь 3500 кг-аас илүүгүй "B" ангиллын бага оврын ачааны автомашин	5000
	Бүх жин нь 7500 кг-аас илүүгүй "C1" ангиллын дунд оврын ачааны автомашин	10000
	"C" ангиллын том оврын ачааны автомашин ("D" ангилалд хамаарахаас бусад бүх жин нь 3500 кг-аас их автомашин)	15000
	"CE" ангиллын чиргүүлтэй ачааны автомашин (бүх жин нь 750 кг-аас илүү чиргүүлтэй "C" ангиллын автомашин)	20000
Бусад	Мотоцикл	2000

-----o0o-----